



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.03.26. № 04/588

танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Иймд тэтгэвэр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа нийт тэтгэвэр авагчдын одоо авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлнэ.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөхөөс өмнө буюу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2 тусдаа тэтгэвэр тогтоолгон авч байгаа тэтгэвэр авагчийн хувьд тэтгэвэр тус бүрийг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлнэ.

3.2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд нийгмийн даатгалын байгууллага холбогдох баримт бичгийг нь хүлээн авсан боловч нийгмийн даатгалын шинэ систем нэвтрүүлж байгаатай холбогдуулан тэтгэвэр нь бодогдоогүй дараах иргэдийн тэтгэврийг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлнэ:

3.1.Ажил олгогчийн 2024 оны 1, 2, 3 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцоо, сайн дураар даатгуулагчийн мөн хугацааны тооцоо хийгдээгүйгээс тэтгэвэр нь тогтоогдоогүй байсан иргэдийн бодогдсон тэтгэврийг;

3.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр,

тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг хангасан 2024 оноос өмнөх цалин хөлсний дунджаас тэтгэврээ бодуулахаар хүлээгдэж байгаа иргэдийн бодогдсон тэтгэврийг;

3.3.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-т заасны дагуу цэргийн алба хаасан 1 жилийг 1 жил 6 сар иргэний байгууллагад ажиллан шимтгэл төлсөн хугацаанд тооцуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг.

4.Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа бүрэн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээ (550 000 төгрөг)-гээр тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг 650 000 (зургаан зуун тавин мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ (440 000 төгрөг)-гээр тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг 540 000 (таван зуун дөчин мянга) төгрөгөөр өөрчилнө.

5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээ (660 000 төгрөг)-гээр тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг 760 000 (долоон зуун жаран мянга) төгрөгөөр өөрчилнө.

6.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй 3 ба түүнээс дээш гишүүнд олгох тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэврийн доод хэмжээ (550 000 төгрөг)-гээр тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг 650 000 (зургаан зуун тавин мянга) төгрөгөөр өөрчилнө.

7.2024 оны 03 дугаар сард нас барсан тэтгэвэр авагчийн нас барсны дараа сар буюу 4 дүгээр сарын тэтгэврийг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлэн олгоно.

8.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг 2 буюу түүнээс дээш гэр бүлийн гишүүнд хуваан олгож байгаа тохиолдолд тэтгэврийн нэмэгдэл (100 000 төгрөг)-ийг гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоонд тэнцүү хувааж тус тусын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу тэтгэврийг нь өөрчлөн тогтоож байгаа болон мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо 5 жилийн дундаж цалин хөлсөөр өөрчлөн тогтоолгож байгаа тэтгэвэр авагчийн өөрчлөн бодсон тэтгэврийг 100 000 (нэг зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлнэ.

10.2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч тэтгэврийн нэмэгдэлд хамаарахгүй.

11.2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээ 650 000 (зургаан зуун тавин мянга), нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 540 000 (таван зуун дөчин мянга), энэ

зөвлөмжийн 5-д заасан тэтгэврийн доод хэмжээ 760 000 (долоон зуун жаран мянга) төгрөг байна.

12.Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт байгаа хамгийн сүүлийн тогтоолтын хуудсан дээр тэтгэврийн нэмэгдлийн бичилтийг холбогдох байцаагчаар хийлгэн гарын үсэг, тэмдгээр баталгаажуулна.

13.Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор Мэдээллийн технологийн төв тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэн тооцох тул тэтгэвэр авагч бүрийн тэтгэврийн нэмэгдлийг нягтлан шалгаж, тэтгэврийн нэмэгдлийн файлыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор бэлтгэж харилцагч банкуудад хүргүүлэх хэрэгтэй.

Засгийн газрын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай тогтоолыг албажиж ирэх үед та бүхэнд хүргүүлэх болно.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ
ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ

